



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Халхгол сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДОА-2026/127/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p> <p>Дорнод аймаг</p> <p>2026 он</p>	<p>Дорнод аймаг дахь Төрийн аудитын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 7058-4203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Д.Нармандах Утас: 7058-4207 Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn</p> <p>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Хаан консалтинг аудит ХХК Гүйцэтгэх захирал: Э.Нандинчимэг Утас: 88883776 Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Баянтүмэнгийн гудамж, 9 дүгээр баг  
Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000  
Утас: 7058-4203

Аудит № 142  
танай ДООБ.ОТ.ДБ ны № 03/48 -Т

ДОРНОД АЙМГИЙН ХАЛХГОЛ СУМЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА  
Э.МӨНХЧИМЭГ ТАНАА

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Халхгол сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 123.4 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давж, дангаараа буюу нийт дүнгээрээ материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, оршин байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.8-д заасан заалтыг зөрчиж 4.7 сая төгрөгийн зөрчил гаргасан;
2. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хориглосон чиглэлээр 2025 оны төсвийг 58.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгосон;
3. Норм, нормативыг хэтрүүлсэн, бараа материалын бүртгэлийн 1.6 сая төгрөгийн зөрчил;

2126050047

### **Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

### **Бусад асуудлын хэсэг**

Дорнод аймгийн Халхгол сумын ИТХ-ын 2025 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 08/08 тогтоолоор 2025 оны үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөг "Хангалттай" гэж дүгнэсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>400,643,182.40</b>	<b>404,827,072.36</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	12,436,562.76	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	12,436,562.76	
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>388,206,619.64</b>	<b>404,827,072.36</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>3,650,500.00</b>	<b>3,975,500.00</b>
35110	Тусгай зориулалттай материал	3,650,500.00	3,975,500.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>153,972,401.64</b>	<b>170,267,854.36</b>
35410	Бичиг хэргийн материал	419,500.00	470,500.00
35420	Аж ахуйн материал	146,231,901.64	150,820,354.36
35430	Сэлбэг хэрэгсэл	3,771,000.00	15,577,000.00
35470	Бусад хангамжийн материал	3,550,000.00	3,400,000.00
35600	Мал амьтад	230,583,718.00	230,583,718.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>4,075,018,668.46</b>	<b>3,947,140,320.76</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	4,075,018,668.46	3,947,140,320.76
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	3,685,480,468.57	3,217,139,688.76
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,564,277,799.39	1,388,822,744.39
39202	Хуримтлагдсан элэгдэл	(311,104,376.30)	(346,542,268.52)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	409,108,800.00	409,108,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(164,044,081.31)	(227,646,414.47)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	252,082,195.00	222,103,945.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(121,664,935.55)	(110,638,354.56)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	184,651,376.51	184,651,376.51
39208	Хуримтлагдсан элэгдэл	(104,412,496.94)	(117,652,367.55)
39209	Зам, гүүрийн байгууламж	473,318,589.00	473,318,589.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(248,746,285.13)	(276,325,804.97)
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,933,075,959.00	3,174,768,735.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,181,062,075.10)	(1,556,829,291.07)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	389,538,199.89	730,000,632.00
39301	Програм хангамж	3,202,200.00	3,202,200.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(3,077,200.11)	(3,202,200.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	389,413,200.00	730,000,632.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>4,475,661,850.86</b>	<b>4,351,967,393.12</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>12,838,271.29</b>	<b>0.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	12,838,271.29	0.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	12,838,271.29	0.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	12,838,271.29	
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	0.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>4,462,823,579.56</b>	<b>4,351,967,393.12</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	4,462,823,579.56	4,351,967,393.12
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,803,935,069.39	1,803,935,069.39
51101	Өмч: - төрийн	1,803,935,069.39	1,803,935,069.39
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	1,984,684,785.45	1,873,828,599.01
51210	Өмнөх үеийн үр дүн	1,013,905,246.97	2,050,738,874.92
51220	Тайлант үеийн үр дүн	970,779,538.48	(176,910,275.91)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	674,203,724.72	674,203,724.72
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>4,475,661,850.85</b>	<b>4,351,967,393.12</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>3,700,929,651.01</b>	<b>2,360,736,060.72</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,139,931,590.97</b>	<b>382,886,048.72</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>1,139,931,590.97</b>	<b>382,886,048.72</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	23,632,688.00	3,538,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,860,688.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	14,772,000.00	3,538,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	952,267,124.33	369,112,776.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	164,031,778.64	10,235,272.72
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,560,998,060.04</b>	<b>1,977,850,012.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>121,525,455.04</b>	<b>10,823,329.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	114,354,180.04	10,823,329.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,171,275.00	-
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>2,439,472,605.00</b>	<b>1,967,026,683.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	2,439,472,605.00	1,967,026,683.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,662,112,527.24</b>	<b>2,537,646,336.63</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,426,559,597.24</b>	<b>2,365,466,336.63</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,250,021,113.95</b>	<b>1,867,624,614.86</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>636,001,148.59</b>	<b>771,941,271.34</b>
210101	Үндсэн цалин	636,001,148.59	771,941,271.34
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>79,004,201.21</b>	<b>97,198,417.53</b>
210201	Тэтгэврийн даатгал	54,162,642.07	66,348,160.11
210202	Тэтгэмжийн даатгал	6,379,153.87	7,786,232.13
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,443,643.07	4,749,165.65
210204	Ажилгүйдлийн даатгал	1,431,800.00	1,949,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12,586,962.20	16,365,259.64
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>42,177,027.94</b>	<b>89,506,502.93</b>
210301	Гэрэл, цахилгаан	11,179,527.94	12,706,502.93
210302	Түлш, халаалт	30,397,500.00	73,920,000.00
210303	Цэвэр, бохир ус	600,000.00	2,880,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>85,802,307.04</b>	<b>45,889,223.00</b>
210401	Бичиг хэрэг	3,939,300.00	3,540,750.00
210402	Тээвэр, шатахуун	38,874,980.04	25,559,661.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,475,110.00	4,205,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	626,700.00	671,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,972,211.00	3,460,592.00
210408	Бараа материал акталсны зардал	34,914,006.00	8,451,420.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>12,452,100.00</b>	<b>4,618,500.00</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		259,900.00
210604	Урсгал засвар	12,452,100.00	4,358,600.00

Дорнод аймгийн Халхгол сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	23,560,600.00	8,726,000.00
210702	Дотоод албан томилолт	23,560,600.00	8,726,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	14,676,442.00	10,484,339.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,642,993.00	7,491,468.00
210803	Даатгалын үйлчилгээ	201,000.00	548,310.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	962,200.00	709,676.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	110,000.00	154,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,030,000.00	692,000.00
210807	Газрын төлбөр	3,730,249.00	888,885.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	1,356,347,287.17	839,260,361.06
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	837,130,267.50	209,746,870.90
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	553,500.00	15,355,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	518,663,519.67	614,157,590.16
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	176,538,483.29	497,841,721.77
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	55,633,499.98	40,997,347.90
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		22,392,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	24,750,000.00	
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	30,883,499.98	18,605,347.90
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	120,904,983.31	456,844,373.87
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	120,904,983.31	456,844,373.87
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>235,552,930.00</b>	<b>172,180,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	235,552,930.00	172,180,000.00
223001	Бусад хөрөнгө	235,552,930.00	172,180,000.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>1,038,817,123.77</u></b>	<b><u>(176,910,275.91)</u></b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	68,037,585.29	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	40,984,187.29	
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	27,053,398.00	
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	(68,037,585.29)	-
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>970,779,538.48</u></b>	<b><u>(176,910,275.91)</u></b>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>2,584,630,748.04</u></b>	<b><u>1,981,388,012.00</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>23,632,688.00</b>	<b>3,538,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	23,632,688.00	3,538,000.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	23,632,688.00	3,538,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,860,688.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	14,772,000.00	3,538,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,560,998,060.04</b>	<b>1,977,850,012.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	121,525,455.04	10,823,329.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	114,354,180.04	10,823,329.00

131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,171,275.00	-
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	2,439,472,605.00	1,967,026,683.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	2,439,472,605.00	1,967,026,683.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,943,014,512.04</b>	<b>1,761,295,635.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,943,014,512.04</b>	<b>1,761,295,635.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,766,476,028.75</b>	<b>1,263,453,913.23</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	635,539,274.44	772,342,979.87
210101	Үндсэн цалин	635,539,274.44	772,342,979.87
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	79,064,366.83	97,198,417.53
210201	Тэтгэврийн даатгал	54,222,807.69	66,348,160.11
210202	Тэтгэмжийн даатгал	6,379,153.87	7,786,232.13
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,443,643.07	4,749,165.65
210204	Ажилгүйдлийн даатгал	1,431,800.00	1,949,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12,586,962.20	16,365,259.64
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	42,177,027.94	89,506,502.93
210301	Гэрэл, цахилгаан	11,179,527.94	12,706,502.93
210302	Түлш, халаалт	30,397,500.00	73,920,000.00
210303	Цэвэр, бохир ус	600,000.00	2,880,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	51,158,290.04	37,558,803.00
210401	Бичиг хэрэг	3,939,300.00	3,661,750.00
210402	Тээвэр, шатахуун	38,874,980.04	25,559,661.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,475,110.00	4,205,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	626,700.00	671,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,242,200.00	3,460,592.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	401,400.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	401,400.00	
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	20,143,500.00	21,189,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,503,600.00	5,585,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	661,300.00	910,000.00
210604	Урсгал засвар	14,978,600.00	14,694,600.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	23,560,600.00	8,726,000.00
210702	Дотоод албан томилолт	23,560,600.00	8,726,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	22,191,442.00	11,484,339.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,157,993.00	8,491,468.00
210803	Даатгалын үйлчилгээ	201,000.00	548,310.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	962,200.00	709,676.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	110,000.00	154,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,030,000.00	692,000.00
210807	Газрын төлбөр	3,730,249.00	888,885.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	892,240,127.50	225,447,270.90
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	891,686,627.50	210,091,370.90
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	553,500.00	15,355,900.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>176,538,483.29</b>	<b>497,841,721.77</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	55,633,499.98	40,997,347.90
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	22,392,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	24,750,000.00	

213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	30,883,499.98	18,605,347.90
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	120,904,983.31	456,844,373.87
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	120,904,983.31	456,844,373.87
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>641,616,236.00</b>	<b>220,092,377.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>641,616,236.00</b>	<b>220,092,377.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>641,616,236.00</b>	<b>220,092,377.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	641,616,236.00	220,092,377.00
223001	Бусад хөрөнгө	641,616,236.00	220,092,377.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(641,616,236.00)</b>	<b>(220,092,377.00)</b>

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,803,935,069.39	674,203,724.72	1,013,905,246.97	3,492,044,041.08
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,803,935,069.39	674,203,724.72	1,013,905,246.97	3,492,044,041.08
Тайлант үеийн үр дүн	-	-	970,779,538.48	970,779,538.48
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,803,935,069.39	674,203,724.72	1,984,684,785.45	4,462,823,579.56
2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,803,935,069.39	674,203,724.72	1,984,684,785.45	4,462,823,579.56
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	66,054,089.47	66,054,089.47
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,803,935,069.39	674,203,724.72	2,050,738,874.92	4,528,877,669.03
Тайлант үеийн үр дүн	-	-	(176,910,275.91)	(176,910,275.91)
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>1,803,935,069.39</b>	<b>674,203,724.72</b>	<b>1,873,828,599.01</b>	<b>4,351,967,393.12</b>

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
<b>11000</b>	<b>Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл</b>	-		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,629,043,900.00</b>	<b>1,081,101,711.26</b>	<b>547,942,188.74</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,629,043,900.00</b>	<b>1,081,101,711.26</b>	<b>547,942,188.74</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,629,043,900.00</b>	<b>1,081,101,711.26</b>	<b>547,942,188.74</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	974,942,400.00	772,342,979.90	<b>202,599,420.10</b>
210101	Үндсэн цалин	971,823,400.00	772,342,979.90	<b>199,480,420.10</b>
210104	Урамшуулал	3,119,000.00		<b>3,119,000.00</b>
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>121,867,700.00</b>	<b>97,198,417.53</b>	<b>24,669,282.47</b>

Дорнод аймгийн Халхгол сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210201	Тэтгэврийн даатгал	82,870,100.00	66,348,160.11	<b>16,521,939.89</b>
210202	Тэтгэмжийн даатгал	9,749,600.00	7,786,232.13	<b>1,963,367.87</b>
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,799,900.00	4,749,165.65	<b>3,050,734.35</b>
210204	Ажилгүйдлийн даатгал	1,949,600.00	1,949,600.00	<b>0.00</b>
210205	Эрүүл мэндийн даатгал	19,498,500.00	16,365,259.64	<b>3,133,240.36</b>
<b>2103</b>	<b>БАЙР АШИГЛАЛТТАЙ ХОЛБООТОЙ ТОГТМОЛ ЗАРДАЛ</b>	<b>110,800,000.00</b>	<b>89,506,502.93</b>	<b>21,293,497.07</b>
210301	Гэрэл, цахилгаан	34,000,000.00	12,706,502.93	<b>21,293,497.07</b>
21302	Түлш халаалт	73,920,000.00	73,920,000.00	<b>0.00</b>
21303	Цэвэр, бохир ус	2,880,000.00	2,880,000.00	<b>0.00</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>44,488,100.00</b>	<b>32,309,142.00</b>	<b>12,178,958.00</b>
210401	Бичиг хэрэг	4,939,000.00	3,661,750.00	<b>1,277,250.00</b>
210402	Тээвэр, шатахуун	27,000,000.00	20,800,000.00	<b>6,200,000.00</b>
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,371,000.00	4,115,700.00	<b>1,255,300.00</b>
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,797,100.00	671,100.00	<b>1,126,000.00</b>
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйл	5,381,000.00	3,060,592.00	<b>2,320,408.00</b>
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>27,916,800.00</b>	<b>10,910,671.00</b>	<b>17,006,129.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	24,058,100.00	7,917,800.00	<b>16,140,300.00</b>
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	87,000.00		<b>87,000.00</b>
210803	Даатгалын үйлчилгээ	973,600.00	548,310.00	<b>425,290.00</b>
210804	Тээврийн хэрэгслийн татвар	856,200.00	709,676.00	<b>146,524.00</b>
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	156,400.00	154,000.00	<b>2,400.00</b>
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээ	896,300.00	692,000.00	<b>204,300.00</b>
210807	Газрын төлбөр	889,200.00	888,885.00	<b>315.00</b>
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>327,872,200.00</b>	<b>60,228,650.00</b>	<b>267,643,550.00</b>
<b>210901</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>312,516,300.00</b>	<b>44,872,750.00</b>	<b>267,643,550.00</b>
<b>210902</b>	<b>Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх</b>	<b>15,355,900.00</b>	<b>15,355,900.00</b>	<b>0.00</b>
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>21,156,700.00</b>	<b>18,605,347.90</b>	<b>2,551,352.10</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>21,156,700.00</b>	<b>18,605,347.90</b>	<b>2,551,352.10</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад олгох	19,000,000.00	18,605,347.90	<b>394,652.10</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,156,700.00		<b>2,156,700.00</b>
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,983,679,000.00</b>	<b>1,970,564,683.00</b>	<b>13,114,317.00</b>
<b>1310</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,584,071,600.00</b>	<b>1,967,026,683.00</b>	<b>-</b>
132001	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,584,071,600.00	1,967,026,683.00	<b>-</b>
	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>399,607,400.00</b>	<b>3,153,000.00</b>	<b>396,454,400.00</b>
	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих			<b>0.00</b>
	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,000,000.00	3,153,000.00	<b>2,847,000.00</b>
	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	393,607,400.00		<b>393,607,400.00</b>

	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>400,000.00</b>	<b>385,000.00</b>	<b>15,000.00</b>
	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		385,000.00	-385,000.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>10,823,329.00</b>	<b>10,823,329.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>10,823,329.00</b>	<b>10,823,329.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>10,823,329.00</b>	<b>10,823,329.00</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>5,249,661.00</b>	<b>5,249,661.00</b>
210402	Тээвэр, шатахуун	4,759,661.00	4,759,661.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	90,000.00	90,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйл	400,000.00	400,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>573,668.00</b>	<b>573,668.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	573,668.00	573,668.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>5,000,000.00</b>	<b>5,000,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.00	5,000,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>10,823,329.00</b>	<b>10,823,329.00</b>
<b>13</b>	<b>ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>		
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>10,823,329.00</b>	<b>10,823,329.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,823,329.00	10,823,329.00

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 340.6 сая төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс, аудитын явцад 340.6 сая төгрөгийн 2 алдааг залрууллаа.

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой алдааг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

*Залруулсан алдаа:*

- Үндсэн хөрөнгөөр бүртгэж хүлээн аваагүй зураг төсвийн капиталжуулах 320.8 сая төгрөгийн зураг төсвийг үндсэн хөрөнгө дансанд бүртгэж элэгдэл байгуулсаныг биет бус хөрөнгө руу шилжүүлэн залруулав. Энэ нь УСНББОУС 01, санхүүгийн тайлангийн оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Өв соёлын өргөө хашааны 19.7 сая төгрөгийн санхүүжилтийг үндсэн хөрөнгө дансанд бүртгэсэнийг биет бус хөрөнгө руу шилжүүлэн залруулав. Энэ нь УСНББОУС 01, санхүүгийн тайлангийн оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 143.2 сая төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс 6.3 сая төгрөгийн 3 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 76.1 сая төгрөгийн 4 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 60.7 сая төгрөгийн 3 зөрчилд зөвлөмж өгөв.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 123,430.3 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 87,948.4 мянган төгрөгөөр давсан тул Хязгаарлалттай дүгнэлт өгөв.

## 5.1 Төлбөрийн акт

1. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасныг зөрчиж бараа материалын үлдэгдэл, орлого зарлагын зөрүүтэй 0.7 сая төгрөгийн гүйлгээ хийсэн.
2. Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журмын 2.4-т "Албан томилолтоор ажилласан хоногийн тоог албан томилолтоор ажиллуулах шийдвэрт тэмдэглэсэн хуанлийн хоногоор тооцож гаргана. Албан томилолтоор явсан, буцаж ирсэн өдрийг нэгтгэн нэг хоногт тооцно" гэж заасныг зөрчиж илүү хоногоор тооцон 0.8 сая төгрөгийн илүү олгосон байна.
3. Төсвийн тухай хуулийн 22.1-т "Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн "15.1.8.байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах", Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.6-д "шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэг"-ийг олгохдоо зориулалтын бус үйл ажиллагааг 4.7 сая төгрөгөөр санхүүжүүлсэн.

## 5.2 Албан шаардлага

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4.2.1-т "зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттайгаар зохион байгуулах", Төсвийн тухай хуулийн 6.3.4-т "төсвийн жилийн явцад шинээр бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламж, тэдгээрээр санхүүжүүлсэн үйл ажиллагааны зарлага нь төсвийн бүрэлдэхүүн байх", 6.4-т "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ", 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.2-т "төрийн болон орон нутгийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх" гэсэн заалтуудыг зөрчиж 2025 оны 8 сард төсвийн тодотголыг хийхдээ биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах дэмжлэгт зориулахаар 58.5 сая төгрөгөөр төсөвлөсөн нь үр ашигтай, хэмнэлттэй байх зарчмыг хангахгүй байна.
2. Төсвийн тухай хуулийн 22.1-т "Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.2.7-т "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг амралт, сувилал, жуулчны баазад зохион байгуулахгүй байх, шаардлагатай бол хот суурин газарт зориулалтын хурлын танхимд, эсхүл цахимаар зохион байгуулах зэргээр түрээс, шатахуун, албан томилолтын зардлыг хэмнэх"- гэж заасныг ЗДТГазар нь 210902 Сургалт, дадлага бэлтгэлийн зардал дансаар 2025 оны 4 сар, 11 сард БНСУ-д туршлага солилцох зорилгоор гадаад томилолтын нийт 15.0 сая төгрөгийн зардлыг гаргасан байна.
3. Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67.2-т "Засаг даргын тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг Засгийн газраас нэг бүрчлэн буюу нэг маягаар тогтоох бөгөөд нийслэлийн Засаг даргын тамгын газар нь газар, хэлтэс, тасагтай, аймаг, сум, дүүргийн Засаг даргын тамгын газар нь хэлтэс, тасагтай байна", Засгийн газрын 267 тогтоолоор "Хүн амын тоо,

газар нутгийн хэмжээ, үйлчлэх өрх, аж ахуйн нэгж, байгууллагын тоог харгалзан сумын Засаг даргын Тамгын газрын орон тооны дээд хязгаарыг 1500 хүртэл хүн амтай суманд 13, 1501-3000 хүртэл хүн амтай суманд 15, 3001-5000 хүртэл хүн амтай суманд 16, 5001-10000 хүртэл хүн амтай суманд 18, 10001-20000 хүртэл хүн амтай суманд 21, 20001-ээс дээш хүн амтай суманд 23 байхаар тус тус тогтоосугай" гэж заасантай нийцэхгүй 7 орон тоогоор хэтрүүлэн ажиллаж байна.

4. Засаг даргын тамгын газрын дарга Э.Мөнхчимэгт 5 жилийн тэтгэмж олгосон 9,817,000 төгрөгөөс, Хууль эрх зүй дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн А.Энхжаргалд 5 жилийн тэтгэмж 7,087,176 төгрөгөөс олгосон ба ХХОАТ-ын 10% болох 1.7 сая төгрөгийг суутган тооцож шилжүүлээгүй нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1-д "Ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого", 7.1.6-д "Үндсэн ажлын газраас бусад хуулийн этгээд болон хувь хүнтэй байгуулсан гэрээний үндсэн дээр ажил, үүрэг гүйцэтгэж авсан хөдөлмөрийн хөлс, шагнал, нэмэгдэл, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого" гэж заасантай нийцэхгүй байна.
5. Зам,тээврийн хөгжлийн яамны 2019 оны 12 дугаар сарын 30 ны өдрийн 390 дугаар тоот тушаалаар баталсан "Автомашинны 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм"-ыг 0.9 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгийн бүртгэл, тайлагнал  
Илрүүлэлт: Төсвийн тухай хуулийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", төсвийн байгууллагын тухайн жилийн батлагдсан төсвөөс тооцох жижиг мөнгийн сангийн хэмжээнээс хэтэрсэн дүнгээр байгууллагын няравын харилцах дансаар бусдад өгөх тусламж, арга хэмжээ зохион байгуулах санхүүжилтийн гүйлгээ хийгдсэн байна. Энэ нь УСНББОУС 01, эрх ба үүрэг нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.  
Өгсөн зөвлөмж: Байгууллагын няравын харилцах дансаар санхүүжилт хийхгүй байх.
2. Гэрээний үүргийн биелэлтийг баталгаажуулах  
Илрүүлэлт: Барилгын тухай хуулийн "14.8.Улс, орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх барилга байгууламжид энэ хуулийн 14.3-т заасан хугацаанд гүйцэтгэгчээс хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гэрээний үнийн дүнгийн тодорхой хувийг уг хугацаа дуустал барьцаалах нөхцөлийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 42.6-д заасны дагуу зохицуулна", ТБОНӨХАҮХААЗХуулийн 42.5."Бараа, ажил, үйлчилгээний чанарын баталгаа болон зүгшрүүлэх, тохируулах хугацаанд гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор захиалагч худалдан авах гэрээний үнийн дүнгийн 5-10 хувийг барьцаалах нөхцөлийг тендер шалгаруулалтын баримт бичигт тусгаж болно" гэж заасантай нийцэхгүй байна.  
Өгсөн зөвлөмж: Чанарын баталгаанд гэрээний үнийн дүнгийн 5-10 хувийг барьцаа болгон авах

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын байгууллагад 30 хоногийн дотор, харин зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 6 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/					
							Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй			
Үндсэн хөрөнгөөр бүртгэж хүлээн аваагүй зураг төсвийн капиталжуулах зардлыг биет бус хөрөнгө рүү шилжүүлэн бүртгэх	1	320,855.0					1	320,855.0				
Өв соёлын өргөө хашааны санхүүжилтийг үндсэн хөрөнгөнөөс биет бус хөрөнгө рүү шилжүүлэн бүртгэх	1	19,732.4					1	19,732.4				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>340,587.4</b>					<b>2</b>	<b>340,587.4</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Автомашин 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг нормыг хэтрүүлэн зарцуулсан	1	957.5			1	957.5						
Шатахууныг бараа материалын орлогод бүртгэлгүй шууд зардал гаргасан	1	729.5	1	729.5								
Дотоод албан томилолтыг илүү хоногоор тооцон олгосон	1	868.0	1	868.0								
Засаг даргын нөөц хөрөнгөнөөс зориулалтын бусаар зарцуулсан	1	4,772.0	1	4,772.0								
2 хүнд олгосон 5 жилийн тэтгэмжээс ХХОАТ суутгаагүй	1	1,690.4			1	1,690.4						
Төсвийн тодотголыг	1	58,500.0			1	58,500.0						

Дорнод аймгийн Халхгол сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

спортын тэмцээн уралдаан зохион байгуулах дэмжлэгт зориулсан												
Гадаад томилолтын зардлыг сургалт, дадлага бэлтгэлийн зардлын дансанд бүртгэсэн	1	15000,0			1	15,000.0						
Байгууллагын няравын дансаар арга хэмжээ зохион байгуулах санхүүжилт шилжүүлсэн	1	40,912.9					1	40,912.9				
<b>Дүн</b>	<b>8</b>	<b>123,430.3</b>	<b>3</b>	<b>6,369.5</b>	<b>4</b>	<b>76,147.9</b>	<b>1</b>	<b>40,912.9</b>				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ТБОНӨХБАҮХА хуулийн хэрэгжилт								
Гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор захиалагч худалдан авах гэрээний үнийн дүнгийн 5-10 хувийг барьцаалах	1	19,732.4					1	19,732.4
УИХ-ын 48 дугаар тогтоолын хэрэгжилтийг хэрэгжүүлээгүй, 7 орон тоогоор хэтрүүлэн ажиллаж байна					1	-	1	-
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>19,732.4</b>			<b>1</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>19,732.4</b>